



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 121

Улаанбаатар хот

Г Хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтооюур баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний 2.118 дугаар зорилтын 7 дахь заалт, “Зам, тээврийн салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сан”-гийн Удирдах зөвлөлийн 2017 оны 2 дугаар тэмдэглэлийн 4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зам, тээврийн салбарын стандарт, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг “Зам, тээврийн салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сан”-гийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар /Р.Мэргэн/-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Зам, тээврийн салбарын стандартыг шинэчлэн боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөрийг батлах тухай” Зам, тээврийн сайдын 2013 оны 85 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Д.ГАНБАТ



Зам, тээврийн хөгжлийн сайдын  
2017 оны 06 дугаар сарын 15 өдрийн  
121 тоот тушаалтын хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН СТАНДАРТ, ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧГИЙГ  
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХӨТӨЛБӨР

УХА0382  
1116126781

## Нэг. Нийтлэг үндэслэл

### 1.1. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, Авто замын тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль, "Төлөвлөгөө батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 89 дүгээр тогтоолд тусгагдсаны дагуу Зам, тээврийн сайдын 2013 оны 85 дугаар тушаалаар батлагдсан "Зам, тээврийн салбарын стандартыг шинэчлэн боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөр"-ийг 2013-2016 онд хэрэгжүүлсэн байна.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд зам, тээврийн салбарын хүрээнд 2012 онд 14, 2013 онд 33, 2014 онд 45, 2015 онд 39, 2016 онд 131 стандартыг Стандартчиллын үндэсний зөвлөлөөр тус тус хэлэлцүүлэн нийт 248 стандартыг батлуулсан байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2013-2016 онд нийт 1,46 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байсан бөгөөд "Зам, тээврийн салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сан"-гийн 2014-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан стандарт, норм, судалгааны ажилд нийт 1,46 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

"Зам, тээврийн салбарын стандартчиллын тогтолцоог шинэчлэн боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөр"/2013-2016/-ийн хэрэгжилтийг "Зам, тээврийн салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сан"-гийн Удирдах зөвлөлийн 2017 оны 2 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахаар шийдвэрлэсэн байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Зам, тээврийн салбарын стандарт, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх" зорилтыг дэвшүүлсэн нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

### Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Монгол Улсын зам, тээврийн салбарт стандарт, норм норматив, техникийн баримт бичгийн тогтолцоог олон улсын жишигт хүргэж, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх техникийн нөхцөлийг бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1. үндэсний стандарт, норм норматив, техникийн баримт бичгүүдийг шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, дахин хянах;

2.2.2. олон улсын болон бус нутгийн стандарт, норм норматив, техникийн баримт бичгүүдийг үндэсний стандарт, норм, техникийн баримт бичиг болгон нутагшуулах;

2.2.3. сургалт, сурталчилгаа болон хэрэгжилтийн ажлыг зохион байгуулах.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1. төр, нийгмийн эрх ашигт нийцэх;

3.1.2. оролцогч талуудыг эрх тэгш байдлыг хангах;

3.1.3. стандарт, норм норматив, техникийн баримт бичгийг олон улсын жишигт хүргэх;

3.1.4. хууль тогтоомжид нийцэхгүй үзүүлэлт, шаардлагыг стандарт, норм норматив, техникийн баримт бичгүүдэд тусгахгүй байх.

Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Үндэсний стандарт, норм норматив, техникийн баримт бичгүүдийг шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, дахин хянах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.1.1. зам, тээврийн салбарт мөрдөж байгаа үндэсний стандарт, норм норматив, техникийн баримт бичгүүдэд шүүлт, стандартын үзлэгийг холбогдох байгууллагуудтай хамтран хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах;

4.1.2. улсын стандартын үзлэг, шүүлтэд үндэслэн улсын стандарт, норм норматив, техникийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах, дахин хянах;

4.1.3. аж ахуй нэгж, олон улсын байгууллагуудын хөрөнгөөр стандарт, норм норматив, техникийн баримт бичгүүдийг боловсруулах ажлыг дэмжих, хамтран ажиллах, стандарт, норм нормативын ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх.

4.2. Олон улсын болон бус нутгийн стандарт, норм норматив, техникийн баримт бичгүүдийг үндэсний стандарт, норм, техникийн баримт бичиг болгон нутагшуулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.2.1. зам, тээврийн салбарт нэвтрүүлэх шаардлагатай Олон улсын стандартчиллын байгууллага (ISO), Америкийн стандартчиллын байгууллага (AASHTO, ASTM) Европын холбоо (CEN), бус нутгийн болон бусад дэвшилтэт

стандарт, норм, техникийн баримт бичгийн судалгааг хийх, үе шаттайгаар нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

4.2.2. Олон улсын болон бус нутгийн болон шинэ дэвшилтэт стандарт, норм норматив, техникийн баримт бичгүүдийг Монгол Улсын үндэсний болгон нутагшуулахад шаардагдах санхүүжилтийг тооцох, эх үүсвэрийг шийдвэрлэх;

4.2.3. олон улсын болон бус нутгийн стандарт, норм, техникийн баримт бичгийн Монгол хэлний орчуулгыг сайжруулах, оролцогч талуудын саналыг авч, боловсруулах, хянан шүүх, салбарын шинжлэх ухаан технологийн зөвлөл, стандартчиллын техникийн хороод хэлэлцүүлэн эрх Зам, тээврийн хөгжлийн сайд, Стандартчиллын үндэсний зөвлөлөөр батлуулж мөрдүүлэх.

4.3. Сургалт, сургалт, сурталчилгаа болон хэрэгжилтийн ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.3.1. стандарт, норм норматив, техникийн баримт бичгүүдийг боловсруулах, орчуулах, хянахад оролцогчид, салбарын техникийн хороодын гишүүдийн чадавхжуулах, давтан сургах, мэргэшүүлэх талаар сургалт зохион байгуулах;

4.3.2. шинээр батлагдсан стандарт, норм норматив, техникийн баримт бичгийн талаар мэдээллийг иргэд, олон нийт, аж ахуй эрхлэгчдэд өгч, тасралтгүй, үе шаттай сурталчилгаа хийж, олон нийтэд зориулсан хураангуй гарын авлага, материалыг бэлтгэн тараах, түгээн дэлгэрүүлэх;

4.3.3. хөтөлбөрийн хэрэгжилтийн ажлыг зохион байгуулж, стандарт, норм, хэмжил, итгэмжлэл, баталгаажуулалт, тохирлын үнэлгээний талаар мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хяналт-шинжилгээ хийж, дүгнэлт гаргах.

#### Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

5.2. Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ ажлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 5.2.1. улсын болон орон нутгийн төсвийн төсөв;
- 5.2.2. салбарын стандарт, норм норматив, техникийн баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сангийн хөрөнгө;
- 5.2.3. олон улсын байгууллага, хандивлагч орны тусламж;
- 5.2.4. аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө;
- 5.2.5. бусад эх үүсвэр.

5.3. "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгагдсаны дагуу "Зам, тээврийн стандарт, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох хөтөлбөр", түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг санхүүжүүлэн ажиллана.

## Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стандарт, нормативын хэлтэс хариуцна.

6.2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг “Зам, тээврийн салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сан”-гийн Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж, тухайн онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган жил бүр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах ажиллана.

6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлэх ажлыг зам, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, стандартчиллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж, салбарын стандартчиллын техникийн хороод (TX15, TX15/DХ01, TX33, TX34)-ын үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.

## Долоо. Хөтөлбөрийн үр дүн

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр зам, тээврийн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангасан, олон улсын жишигт хүрсэн стандарт, норм норматив, техникийн баримт бичгийг боловсруулж, мөрдүүлж, түгээн дэлгэрүүлнэ:

7.1.1. салбарын бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар, хүртээмж, байгууллагуудын чадавх дээшилж, салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирна;

7.1.2. зам, тээврийн салбарт олон улсын жишигт хүрсэн стандарт, норм норматив, техникийн баримт бичгүүдийг нэвтрүүлсэн байна;

7.1.3. зам, тээврийн салбарт шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт техник, технологи нэвтрэх боломж бүрдэнэ.

## Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

8.1. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээг зохих журмын дагуу жил тутам хийнэ.

8.2. Хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг “Зам, тээврийн салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сан”-гийн Хяналтын зөвлөл хариуцан ажиллана.